# ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
# ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДУА-2026/83/НА-СТА-ТШЗ**


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2026 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 2**

**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7**

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9**

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 10**

**5.1 Төлбөрийн акт** ..... 10

**5.2 Албан шаардлага** ..... 11

**5.3 Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал** ..... 12

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 16**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208, 70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.04 № 10

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.ТӨРБИЛЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг болович өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Онцгой байдлын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дундговь аймгийн Онцгой байдлын газар нь 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвийн хөрөнгөөр хийгдсэн барилгын их засварын ажлын зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, зөвшөөрөл аваагүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хүлээн авсан, захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй, захиалагчийн хяналт болон зураг төсөв зохиогчийн хяналтын зардлыг гүйцэтгэгч компанид олгосон, албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны мөнгийг цалингийн сангаас давхардуулан олгосон зэрэг 431.5 сая төгрөгийн материаллаг зөрчил нь тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 9.1 дахин их байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 24 дүгээр зүйлийн 24.6, 29.2.2, Барилгын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.1.2, 37 дугаар зүйлийн 37.1.4, 48 дугаар зүйлийн 48.1, Засгийн газрын 2016 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3.12, Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, зөвшөөрөл олгох" журмын 7.1, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.2.2.5, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан

4826050037

"Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т заасан заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 273.5 сая төгрөгөөр өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон дараах асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байна. Үүнд: Ажилтанд байгууллагын даргын тушаалаар оногдуулсан сахилгын шийтгэлийг, тушаал шийдвэрт заасан хувь хэмжээгээр тухайн албан хаагчийн үндсэн цалингаас тооцож, бодогдсон нийт цалингийн суутгал хэсэгт тусган тайлагнахаар ОБЕГ-ын даргын 2025 оны А/167 дугаар батлагдсан **"Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"**-т тусган хэрэгжүүлж байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 48.1.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2.3. дахь заалтуудтай зөрчилдөж байгаа талаар дүгнэлт гарах шаардлагатай гэж үзлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдагдсан 420.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын их засварын ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүйтэй холбоотой зөрчил нь гэмт хэргийн шинжтэй байх эрсдэлтэй тул хуулийн байгууллагад шалгуулах саналыг Монгол Улсын ерөнхий аудиторт хүргүүлсэн. Дээрх үйл явдлуудыг гол асуудал гэж үзлээ.

**Бусад асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилт, 69 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 82.7 хувьтай үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **865,022,060.40** | **578,815,055.10** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 35,130,900.00 | 00.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 35,130,900.00 | 00.00 |
| **3121** | **Төгрөг** | 35,130,900.00 | 00.00 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 35,130,900.00 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 5,854,900.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 00.00 | 5,854,900.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 829,891,160.40 | 572,960,155.10 |
| **351** | **Түүхий эд материал** | 26,833,564.53 | 108,875,724.53 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 25,399,677.53 | 106,613,437.53 |
| 35130 | Эм боох материал | 1,433,887.00 | 2,262,287.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 803,057,595.87 | 462,990,680.57 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,405,080.00 | 1,170,855.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 16,849,898.00 | 43,734,023.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 86,943,646.01 | 117,240,211.01 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 697,858,971.86 | 300,845,591.56 |
| 35600 | Мал амьтад | 00.00 | 1,093,750.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,422,777,015.27** | **4,600,522,784.69** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,422,777,015.27 | 4,600,522,784.69 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,865,421,015.27 | 4,039,386,784.69 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,901,910,507.11 | 2,321,910,507.11 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -355,972,973.24 | -420,837,501.56 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 3,577,841,813.33 | 3,765,541,813.33 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -1,639,357,561.99 | (1,913,385,239.89) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 808,187,434.18 | 798,786,843.46 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (438,284,271.22) | (534,045,842.85) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 59,522,972.53 | 59,346,362.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (48,455,655.08) | (37,930,157.31) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,730,000.00 | 2,730,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (2,701,250.35) | (2,730,000.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 557,356,000.00 | 561,136,000.00 |
| 39301 | Программ хангамж | 1,100,000.00 | 1,100,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,100,000.00) | (1,100,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 557,356,000.00 | 561,136,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,287,799,075.67** | **5,179,337,839.79** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **00.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,287,799,075.67** | **5,179,337,839.79** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,287,799,075.67 | 5,179,337,839.79 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,402,864,149.56 | 1,402,864,149.56 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,402,864,149.56 | 1,402,864,149.56 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,423,812,009.01 | 3,315,660,643.65 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,423,812,009.01 | 3,424,121,879.53 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -108,461,235.88 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 461,122,917.10 | 460,813,046.58 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,287,799,075.67** | **5,179,337,839.79** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,556,406,949.63** | **4,642,488,767.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,173,720,249.63** | **614,278,542.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,173,720,249.63 | 614,278,542.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,173,720,249.63 | 614,278,542.50 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,173,720,249.63 | 614,278,542.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,382,686,700.00** | **4,028,210,225.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,295,486,500.00 | 3,990,873,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,295,486,500.00 | 3,990,873,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 87,200,200.00 | 37,336,325.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 31,115,600.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 47,828,200.00 | 25,266,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,256,400.00 | 12,070,325.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 00.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,914,352,462.26** | **4,741,798,336.35** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,879,906,328.37** | **4,718,173,686.22** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,879,906,328.37 | 4,718,173,686.22 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,731,881,600.00 | 3,040,424,846.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,403,828,382.00 | 1,701,180,632.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,192,103,018.00 | 1,172,300,090.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 50,103,000.00 | 68,784,000.00 |
| 210104 | Урамшуулал | 85,847,200.00 | 98,160,124.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 69,873,190.00 | 71,728,354.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,924,751.00 | 8,732,013.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,520,560.00 | 1,238,181.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 789,942.00 | 619,091.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 596,809.00 | 504,648.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 54,041,128.00 | 60,634,421.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 114,353,941.61 | 124,585,532.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,148,396.11 | 20,755,804.07 |
| 210302 | Түлш, халаалт | 85,883,377.50 | 88,069,717.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,322,168.00 | 15,760,010.70 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 355,205,799.00 | 114,969,874.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,332,970.00 | 4,808,325.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 134,559,495.15 | 104,799,126.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,299,748.50 | 2,389,023.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 46,080.00 | 384,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,339,100.00 | 2,589,400.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 207,628,405.35 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 79,009,592.00 | 579,542,339.05 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 839,000.00 | 725,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 78,141,792.00 | 107,108,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 28,800.00 | 471,709,139.05 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 91,330,616.10 | 183,631,830.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 15,619,484.10 | 34,840,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,220,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 72,491,132.00 | 148,791,830.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 44,352,000.00 | 25,266,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 44,352,000.00 | 25,266,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 18,414,906.00 | 24,415,073.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,295,950.00 | 16,640,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,460,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,093,864.00 | 1,184,776.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 462,000.00 | 466,356.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,666,000.00 | 1,720,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,437,092.00 | 4,403,341.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 375,484,683.66 | 553,609,837.30 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,754,000.00 | 59,015,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,910,360.00 | 3,090,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 342,820,323.66 | 491,504,437.30 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | 00.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 34,446,133.89 | 23,624,650.13 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,421,950.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,421,950.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 18,024,183.89 | 23,624,650.13 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,024,183.89 | 23,624,650.13 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **642,054,487.37** | **(99,309,568.85)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 32995310.00 | 9151667.03 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 41,667.03 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 32,995,310.00 | 9,110,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **32,995,310.00** | **9,151,667.03** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **609,059,177.37** | **108,461,235.88** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,417,686,700.00** | **4,028,210,225.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **35,000,000.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 35,000,000.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 35,000,000.00 | 00.00 |
| 120009 | Бусад орлого | 35,000,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,382,686,700.00** | **4,028,210,225.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,295,486,500.00 | 3,990,873,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,295,486,500.00 | 3,990,873,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 87,200,200.00 | 37,336,325.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 31,115,600.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 47,828,200.00 | 25,266,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,256,400.00 | 12,070,325.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,187,806,700.00** | **3,643,341,125.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,187,806,700.00** | **3,643,341,125.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,153,360,566.11** | **3,619,716,474.87** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,766,881,600.00 | 3,040,424,846.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,438,828,382.00 | 1,701,180,632.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,192,103,018.00 | 1,172,300,090.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 50,103,000.00 | 68,784,000.00 |
| 210104 | Урамшуулал | 85,847,200.00 | 98,160,124.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 69,873,190.00 | 71,728,354.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,924,751.00 | 8,732,013.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,520,560.00 | 1,238,181.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 789,942.00 | 619,091.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 596,809.00 | 504,648.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 54,041,128.00 | 60,634,421.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 113,011,641.61 | 140,463,032.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,227,596.11 | 20,755,804.07 |
| 210302 | Түлш, халаалт | 84,461,877.50 | 103,947,217.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,322,168.00 | 15,760,010.70 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,935,628.50 | 16,484,314.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,030,500.00 | 2,515,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,220,200.00 | 8,606,191.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,299,748.50 | 2,389,023.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 46,080.00 | 384,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,339,100.00 | 2,589,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 79,332,000.00 | 108,661,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,564,000.00 | 1,553,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 77,768,000.00 | 107,108,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21,599,240.00 | 143,808,455.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,599,240.00 | 143,808,455.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 44,352,000.00 | 25,266,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 18,414,906.00 | 24,415,073.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,295,950.00 | 16,640,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,460,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,093,864.00 | 1,184,776.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 462,000.00 | 466,356.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,666,000.00 | 1,720,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,437,092.00 | 4,403,341.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 20,960,360.00 | 48,464,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,050,000.00 | 45,374,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,910,360.00 | 3,090,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **34,446,133.89** | **23,624,650.13** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,421,950.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,421,950.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 18,024,183.89 | 23,624,650.13 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,024,183.89 | 23,624,650.13 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **229,880,000.00** | **384,869,100.00** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **198,000,000.00** | **420,000,000.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **198,000,000.00** | **420,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 198,000,000.00 | 420,000,000.00 |
| 225102 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ | 198,000,000.00 | 420,000,000.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(198,000,000.00)** | **(420,000,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 31,880,000.00 | (35,130,900.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 3,250,900.00 | 35,130,900.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 35,130,900.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|
| **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,402,864,149.56 | 461,122,917.10 | 3,293,361,339.21 | 5,157,348,405.87 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,402,864,149.56** | **461,122,917.10** | **3,293,361,339.21** | **5,157,348,405.87** |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | (478,608,507.57) | (478,608,507.57) |
| **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,402,864,149.56** | **461,122,917.10** | **3,423,812,009.01** | **5,287,799,075.67** |
| **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,402,864,149.56** | **461,122,917.10** | **3,423,812,009.01** | **5,287,799,075.67** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 309,870.52 | 309,870.52 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,402,864,149.56** | **461,122,917.10** | **3,424,121,879.53** | **5,288,108,946.19** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | (309,870.52) | 00.00 | (309,870.52) |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | (108,461,235.88) | (108,461,235.88) |
| **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,402,864,149.56** | **460,813,046.58** | **3,315,660,643.65** | **5,179,337,839.79** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,995,553,800.00 | 3,967,249,249.87 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,995,553,800.00 | 3,967,249,249.87 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,990,873,800.00 | 3,967,249,249.87 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,053,555,400.00 | 3,040,424,846.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,862,809,400.00 | 1,701,180,632.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,073,408,300.00 | 1,172,300,090.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 58,125,000.00 | 68,784,000.00 |
| 210104 | Урамшуулал | 59,212,700.00 | 98,160,124.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,710,700.00 | 71,728,354.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,445,100.00 | 8,732,013.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,434,500.00 | 1,238,181.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 742,600.00 | 619,091.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,306,700.00 | 504,648.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 62,781,800.00 | 60,634,421.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 141,542,100.00 | 140,463,032.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,818,300.00 | 20,755,804.07 |
| 210302 | Түлш, халаалт | 108,084,500.00 | 103,947,217.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,639,300.00 | 15,760,010.70 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,491,100.00 | 16,484,314.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,494,800.00 | 2,515,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,961,700.00 | 8,606,191.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,058,600.00 | 2,389,023.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 386,500.00 | 384,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,589,500.00 | 2,589,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 108,661,700.00 | 108,661,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,553,500.00 | 1,553,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 107,108,200.00 | 107,108,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 558,244,000.00 | 558,238,130.00 |
| 210604 | Урсгал засвар | 558,244,000.00 | 558,238,130.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 27,817,700.00 | 24,415,073.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,640,600.00 | 16,640,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,308,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,248,600.00 | 1,184,776.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 462,000.00 | 466,356.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,721,400.00 | 1,720,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,437,100.00 | 4,403,341.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,851,100.00 | 6,833,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,744,000.00 | 3,743,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,107,100.00 | 3,090,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,680,000.00 | **00.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,680,000.00 | **00.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,680,000.00 | 00.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,995,553,800.00 | 3,967,249,249.87 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,995,096,300.00 | 3,967,249,249.87 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,995,096,300.00 | 3,967,249,249.87 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 457,500.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 457,500.00 | 00.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **37,336,325.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **37,336,325.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **37,336,325.00** |

| | | |
|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,570,325.00** |
| 210604 | Урсгал засвар | 5,570,325.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **25,266,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 25,266,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **6,500,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,500,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **37,336,325.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **37,336,325.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,266,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,070,325.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,138,270.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 29,479.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 677,331.1 мянган төгрөгийн зөрчил арилгуулах 1 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 11,459.4 төгрөгийн 2 төлбөрийн акт, хүргүүлж, 420,000.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг хуулийн байгууллагад шалгуулахаар хүргүүллээ.

***Залруулсан алдаа:***

Аудитаар нийт **31,218.7** мянган төгрөгийн 2 алдаа[1] илрүүлснийг аудитын явцад залрууллаа.

*1.* Санхүүгийн мөнгөн гүйлгээний тайланд ахмадын сангийн төвлөрүүлэх шилжүүлгийн зардлыг буруу тайлагнасан.

2. Санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн орлого зардлыг илүү тайлагнасан.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д *(холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах),* 20.2.4-д *(Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах")* заалтыг зөрчиж мөн “Иж бүрэн” байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Залруулагдаагүй алдаа:***

Аудитаар нийт 1,108,790.5 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс , 11,459.4 төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 677,331.1 мянган төгрөгийн зөрчил арилгуулах 1 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 420,000.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг хуулийн байгууллагад шалгуулахаар хүргүүлсэн.

### 3.1. Төлбөрийн акт

3.1.1. Албан томилолтоор ажилласан албан хаагчдад **520.0** мянган төгрөгийн хоолны мөнгийг цалингийн сангаас давхардуулан олгосон. Энэ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т *(Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;)*, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-т *(Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал; 2.2.2. байрны зардал; 2.2.3. хоолны зардал)* заасныг;

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1.2. Байгууллагын барилгад хийгдсэн их засварын ажлын төсөвт тусгагдсан захиалагчийн албаны хяналт, зураг төсөв зохиогчийн хяналт, магадалшгүй ажлын зардал **10,939.4** мянган төгрөгийг гүйцэтгэгч компанид олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Барилгын тухай хууль 24 дүгээр зүйлийн 24.1.3-д (*Барилгын үнэ бүрдэл, төсвийн норм, нормативын баримт бичиг, дүрэм, заавар, аргачлалыг удирдлага болгосон байх;)*, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.2.2.5-д (*Төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх;*) заалтыг тус тусзөрчсөн байна.

## 3.2. Албан шаардлага

***Зөрчил арилгуулах албан шаардлага***

3.2.1. Шилэн дансны цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой шийдвэрийг мэдээлээгүй **677,331.1** мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн *(Шилэн дансны зарчим)*, 4.1.1-д *(мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;)*, 4.1.3-т *(тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; )*, 6 дугаар зүйлийн 6.1.1. *(тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;)*, 6.4-т *(Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:)*, 6.4.5.-д *(цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр)*, 6.4.8-д *(бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;)*, 7 дугаар зүйлийн 7.2 -т *(Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.)* заасныг тус тус зөрчсөн байна.

***Хариуцлага тооцуулах албан шаардлага***

3.2.2. Дундговь аймгийн Онцгой байдлын газрын төсвийн шууд захирагч Ц.Төрбилэг нь 2025 онд төсвийн хөрөнгөөр хийгдсэн барилгын их засварын ажлын зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, зөвшөөрөл аваагүй, захиалагчийн хяналтын гэрээ байгуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хүлээн авч, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулж, албан үүргээ биелүүлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6. *(Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ.)*, 29 дүгээр зүйлийн 29.2.2.-д *(барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;)*, Барилгын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.-д *(Энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжид дараах төрлөөр барилгын ажлын зөвшөөрөл олгоно:)*, 26.1.2.-т *(барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэн барих)*, 37 дугаар зүйлийн 37.1.4-т *(барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах)*, 48 дугаар зүйлийн 48.1. *(Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна.)*, Засгийн газрын 2016 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3.12-т *(улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно)*, Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, зөвшөөрөл олгох" журмын 7.1.-д *(Барилгын*

*ажлын зөвшөөрөл зохих ёсоор олгогдоогүй барилга байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг хориглоно)* , Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.-д *(Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.)* заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төсвийг хяналттай, үр ашигтай зарцуулах, ажил гүйлгээг ил тод мэдээлж байх, актын төлбөрийг барагдуулж, төсвийг хохиролгүй болгох, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

## 3.3. Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

3.3.3. Дундговь аймгийн Онцгой байдлын газрын төсвийн шууд захирагч Ц.Төрбилэг нь 2025 онд төсвийн хөрөнгөөр хийгдсэн барилгын их засварын ажлын зураг, төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, зөвшөөрөл аваагүй, захиалагчийн хяналтын гэрээ байгуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хүлээн авсан нь гэмт хэргийн шинжтэй байх эрсдэлтэй тул Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлд зааснаар холбогдох хууль, тогтоомжийн дагуу Прокурорын байгууллагад шилжүүлэн шалгуулах саналыг Монгол Улсын ерөнхий аудиторт хүргүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 431.5 төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 9.1 дахин их тул **“ХЯЗГААРЛАЛТТАЙ”** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн мөнгөн гүйлгээний тайланд ахмадын сангийн төвлөрүүлэх шилжүүлгийн зардлыг буруу тайлагнасан. | 1 | 5,854.9 | - | - | 1 | 5,854.90 | 1 | 5,854.90 | | | | |
| Санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн орлого зардлыг илүү тайлагнасан. | 1 | 23,624.7 | | | 1 | 23,624.7 | 1 | 23,624.7 | | | | |
| **Дүн** | **2** | **29,479.6** | **-** | **-** | **2** | **29,479.6** | **2** | **29,479.6** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны мөнгийг цалингийн сангаас давхардуулан олгосон. | 1 | 520.0 | 1 | 520.00 | | | | | | | | |
| Их засварын ажлын төсөвт тусгагдсан захиалагчийн албаны хяналт, зураг төсөв зохиогчийн хяналт, магадалшгүй ажлын зардлыг гүйцэтгэгч компанид олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. | 1 | 10,939.4 | 1 | 10,939.4 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төсвийн хөрөнгөөр барилга байгууламжид хийгдсэн их засварын ажлын зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгээгүй, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, зөвшөөрөл аваагүй, захиалагчийн хяналтын гэрээ байгуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хүлээн авсан. | 1 | 420,000.0 | | | | | | | | | 1 | 420,000.0 |
| **Нийт дүн** | **3** | **431,459.4** | **2** | **11,459.4** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **420,000.0-** |

**Нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл :** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой шийдвэрийг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. | 1 | 677,331.1 | | | 1 | 677,331.1 | | | | | | |
| **Дүн** | **1** | **677,331.1** | **-** | **-** | **1** | **677,331.1** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | | | | | |
| Төсвийн хөрөнгөөр байгууллагын барилга байгууламжид хийгдсэн их засварын ажлыг хууль журмын дагуу зохион байгуулаагүй, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулж албан үүргээ биелүүлээгүй байна. | 1 | - | | | | | | | 1 | - | | |
| **Дүн** | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **-** | **-** |
| **Нийт дүн** | **2** | **677,331.1** | | | **1** | **677,331.1** | | **-** | **1** | **-** | **-** | **-** |